



ДУЛААНЫ ХОЁРДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/59

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 46.2 дахь хэсэг, 47 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус компанид 180 кВт-н инвертор нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороог дараах бүрэлдхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Дарга: Г.Болдсайхан
/Хангамж, үйлчилгээ хариуцсан дэд захирал/
Нарийн бичгийн дарга: Б.Эрдэнэтогтох
/Худалдан авах ажиллагааны мэргэжилтэн/
Гишүүд: С.Батсайхан
/Цахилгаан, дулааны хянах хэмжүүр автоматикийн цехийн дарга/
Ж.Ханд-Иш
/Монголын эрчим хүчний мэргэшсэн инженерүүдийн зөвлөлийн гишүүн/
Д.Тарваа
/"Аудитын боловсрол төв" ТББ-ын гишүүн/

2. Холбогдох хууль, тогтоомж, заавар, журмын дагуу тендерийн бичиг баримтыг бүрдүүлэн тендерийн ажиллагааг явуулж, үнэлгээний хорооны дүгнэлт, зөвлөмжийг захиалагчид танилцуулахыг үнэлгээний хорооны дарга /Г.Болдсайхан/-д үүрэг болгосугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлэх, Үнэлгээний хорооны гишүүдийн мэдэгдэл, тайлбарыг гаргуулан авч компанийн эрх бүхий албан тушаалтанд хугацаанд нь бүртгүүлэхийг нарийн бичгийн дарга /Б.Эрдэнэтогтох/-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



С.БЯМБААХҮҮ

36001044 Tushaal A4 2019

